



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/555

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн "Өв соёл-Эрч хүч" дэд хөтөлбөрийн хүрээнд сумдын Соёлын төвийн эрхлэгч нарын "Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх нь" сургалтад 1,398,650 (Нэг сая гурван зуун ерэн найман мянга зургаан зуун тавин) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Базар) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир) -д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД